



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/287

Номгон

ГБаянхонгор хотын хүндэтгэлийн хаалга
хийх ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1."а", Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 3.4.83 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.


1.Баянхонгор аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд аймгийн өнгө төрх, түүх соёл, зан заншил, онцлог болон дотоод, гадаадын жуулчдын амрах, аялах орчинг бүрдүүлсэн хүндэтгэлийн хаалга хийх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулсугай.

2.Аймгийн хүндэтгэлийн хаалгыг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Баянхонгор хотын хүндэтгэлийн хаалгыг хийх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, иргэд, олон нийтийн дунд санал асуулга явуулан гарсан дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, шаардагдах төсвийг шийдвэрлүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

521033727

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар
сарын 06-ны өдрийн А/287 дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Г.Нэмэхбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

С.Байгалмаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Намуун - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Мөнхсоёл - Баянхонгор сумын Засаг дарга

Д.Алтангэрэл - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Р.Пүрэвсүрэн - Аймгийн Түүх угсаатны зүй, байгалийн музейн дарга, аймгийн урчуудын эвлэлийн холбооны тэргүүн

Т.Отгонбаатар - "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дарга

С.Баясгалан - "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын дарга

Д.Содномсамдан - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн

Б.Баянжаргал - Аймгийн Гон Гандан Дэдлин хийдийн хамба лам

Г.Олонбаяр - "Хонгорын дугуйчид унадаг дугуйн холбоо"-ны тэргүүн

М.Батбаяр - "Баянхонгор - Хүн үүслийн өлгий" аялал жуулчлалын холбооны тэргүүн

П.Санаадагва - МСНЭ-ийн салбар зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга: Э.Ганзориг - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

оОо

